

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖИЙГ СУУРИЛУУЛАХ,  
ШАЛГАХ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

**НЭГ. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД СУУРИЛУУЛСАН ТАХОГРАФЫГ АШИГЛАХ**

1. Дараах хуулийн этгээд, хувь хүн зохих зорилгын дагуу тахографыг ашиглана:

1.1. жолооч – тээврийн хэрэгсэлийг жолоодсон, амарсан цаг, хугацаа болон хөдөлмөр, амралтын горимыг мөрдөж буй байдалыг бүртгэх, тооцох зорилгоор;

1.2. тээврийн хэрэгсэлийн өмчлөгч – тахографын ажиллагаа болон жолооч хөдөлмөр, амралтын горимыг мөрдөж буй байдалыг хянах зорилгоор;

1.3. хяналтын ажилтнууд - жолооч хөдөлмөр, амралтын горимыг мөрдөж буй байдалыг хянах, тээврийн хэрэгсэл хөдөлгөөны аюулгүй байдал хангаж буй байдалыг хянах зорилгоор;

2. Тээврийн хэрэгсэлд Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн багийн ажлын тухай Европын хэлэлцээрийн шаардлага болон ЗТХЯ-ны сайдын 202.. оны .. сарын .. ний өдөрийн ..... дугаар тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгсэлд суурилуулах тахограф болон картад тавигдах шаардлага”-д нийцсэн, Монгол Улсад хэрэглэхийг зөвшөөрч бүртгэлд орсон нэг тахограф суурилуулж, идэвхжүүлж ашиглана.

3. Тээврийн хэрэгсэлд нэгэн зэрэг хоёр, түүнээс дээш тооны тахограф суурилуулж ашиглахыг хориглоно.

4. Тахографт Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн багийн ажлын тухай Европын хэлэлцээрийн шаардлага болон ЗТХЯ-ны сайдын 202.. оны .. сарын .. ний өдөрийн ..... дугаар тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгсэлд суурилуулах тахограф болон картад тавигдах шаардлага”-д нийцсэн жолоочийн, засвар үйлчилгээний газрын, байгууллагын болон хянагчийн карт ашиглана.

5. Жолоочид нэг карт олгоно.

6. Тахограф ашиглах явцад (эрх бүхий байгууллага болон) АТҮТ дараах бүртгэлийг хөтөлнө:

6.1. Монгол Улсад ашиглахыг зөвшөөрсөн тахографын загвар болон картууд;

6.2. Тахограф нийлүүлэгчээс засвар үйлчилгээний газарт шилжүүлэн өгсөн, идэвхжүүлсэн, устгалд оруулсан тахограф болон картууд;

6.3 Тахографыг суурилуулах, шалгах, техникийн үйлчилгээ хийх, засварлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй засвар үйлчилгээний газарууд;

7. Тахограф ашиглах явцад АТҮТ дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

7.1. карт авах, солих, шинэчлэн сунгах, шилжүүлэх (хянагчийн карт хамаарахгүй) тухай хүсэлт өргөдөлийг хүлээн авах, бүртгэх;

7.2. тахографыг идэвхжүүлэх, карт олгох, дамжуулах үеийн мэдээлэлийн солилцоо.

8. АТҮТ засвар үйлчилгээний газараас ирүүлсэн мэдээлэл дээр суурилан дараах өгөгдөлийн бүртгэлийг нэмж хөтөлнө:

8.1. суурилуулсан тахографын загвар тус бүрээр;

8.2. тахографын картын төрөл, загвар бүрээр;

8.3. засвар үйлчилгээний газар тус бүрээр.

9. Тахограф, карт болон засвар үйлчилгээний газарын жагсаалтын бүртгэлд дараах өгөгдөлийг хамруулна:

9.1. нийлүүлэгч, үйлдвэрлэгч байгууллага болон засвар үйлчилгээний газарын нэр, хаяг;

9.2. тухайн байгууллагын удирдах ажилтан юмуу эрх бүхий ажилтаны овог, нэр;

9.3. тахограф болон картын техникийн үзүүлэлт;

9.4. тахограф болон карт “Тээврийн хэрэгсэлд суурилуулах тахограф болон картад тавигдах шаардлага”-д нийцсэн эсэхийг шалгасан шалгах, туршилт, тестийн үр дүн, түүнийг баталж буй баримт бичиг (түүний хуулбар);

10. Тахограф сууриулсан тээврийн хэрэгсэлийн жолооч дараах үүрэгтэй:

10.1. тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний эхлүүлэхийн өмнө (ээлж юмуу тухай өдөрийн ажил эхлэхийн өмнө) жолоочийн картыг тахографын нэгдүгээр үүрэнд хийж картын ПИН кодыг оруулах. Багаар жолоодож байгаа үед нэгдүгээр жолооч картаа хийж таниулсаны дараа хоёрдугаар жолооч картаа хоёрдугаар үүрэнд хийж ПИН кодоо оруулах;

10.2. тахографын дэлгэц дээр гарч ирсэн хүсэлтийн дагуу өөрийн үйл ажиллагааны төрөл, ажил эхэлж буй байршил, газарын нэрийг гараар оруулах. Хэрэв энэ өгөгдөлийг гараар оруулахгүй бол жолоочийн үйл ажиллагааны төрөл болон ажил эхэлж буй байршилыг автоматаар тодорхойлж бүртгэнэ;

10.3. ажил дууссаны (ээлж дуусах, ажлын өдөр дуусах) дараа жолоочийн картыг үүрнээс авч тахографын дэлгэц дээр гарч ирсэн хүсэлтийн дагуу ажил дууссан тухай болон байршилын тухай баталгаажуулж мэдээлэлийг гараар оруулах.;

10.4. хяналтын байгууллагын төлөөлөгчийн шаардсаны дагуу тахограф болон жолоочийн картад хандах хандалтыг олгох, мөн шаардсан мэдээлэлийг тахографаас

хэвлэж гаргах;

10.5. зохих мэдээлэлийг хэвлэн гаргах;

10.6. бохирдсон, эсхүл гэмтэлтэй карт ашиглахгүй байх;

10.7. тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд байгаа үед картыг үүрнээс гаргахгүй байх;

10.8. жолоочийн картын хүчинтэй хугацаа дууссан хойно ашиглахгүй байх;

10.9. тахографыг “Тээврийн хэрэгсэлд суурилуулах тахограф болон картад тавигдах шаардлага” болон үйлдвэрлэгчийн заавар, удирдамжийн дагуу ашиглах.

11. Тахограф сууриулсан тээврийн хэрэгсэлийн жолоочид дараах зүйлийг хориглоно:

11.1. ажиллахгүй (блокогдсон, өөрчилсөн, эвдрэлтэй) эсхүл “Тээврийн хэрэгсэлд суурилуулах тахограф болон картад тавигдах шаардлага”-д нийцэхгүй, тахограф ашиглан тээвэрлэлт гүйцэтгэх;

11.2. ашиглалтын хугацаа дууссан тахограф ашиглах;

11.3. Монгол улсад ашиглахыг зөвшөөрч бүртгэлд оруулаагүй тахограф ашиглах;

11.4. тахографын бүртгэж буй мэдээлэлийг блоклон хаах, өөрчлөх, засах, хуурамчаар үйлдэх;

11.5. тахограф болон жолоочийн картад хадгалж буй өгөгдөл, түүнчлэн хэвлэсэн мэдээлэлийг устгах;

11.6. шалгагдаагүй, лацдаагүй, хэмжилт нь буруу тахограф ашиглах.

12. Жолоочийн карт гэмтэх, буруу ажиллах, эсхүл хаях, алдах тохиолдолд хуанлийн долоо хоногийн дотор карт олгосон байгууллагад мэдэгдэж шинэ карт авах өргөдөл гаргана.

13. Жолооч тахографын хэвлэсэн хуудас дээр баталгаажсан гарын үсэг зурсан мэдээлэл нэмж болно.

14. Тээврийн байгууллага, тээврийн хэрэгсэл өмчлөгч дараах үүрэгтэй:

14.1. бүртгэлд орсон зөвшөөрөл бүхий засвар үйлчилгээний газарт захиалга өгч тээврийн хэрэгсэлд тахограф суурилуулах, шалгуулах, техникийн үйлчилгээ, засвар хийлгэх;

14.2. тахограц үйлдвэрлэгчийн заавар, удирдамжийн дагуу тахографыг ашиглах үйл явцыг хангах;

14.3. тахографт цаг тухайд нь техникийн үйлчилгээ хийж зохих хуваарийн дагуу ажиллагааг шалгах;

14.4. жолоочийг тахограф ашиглахад шаардлагатай материалаар (принтерийн

цаас) хангах;

14.5. жолоочийн картын өгөгдөлийг сар бүр татаж (ачаалж) авах;

14.6. жолоочийн картаас татаж авсан өгөгдөлийг шалгахад хүртээмжтэй байдлаар нэг жилийн хугацаагаар хадгалах;

14.7. гэмтэлтэй, алдаатай ажилладаг тахографыг бүртгэлд орсон зөвшөөрөлтэй засвар үйлчилгээний газарт илгээж засуулах;

14.8. актлагдаж устгасан тахографын тухай өгөгдөлийг АТҮТ-д илгээх;

14.9. тахографыг устгахын өмнө түүний санах ойд бүртгэгдсэн өгөгдөлийг татан авч нэг жил хадгалах;

14.10. тээврийн хэрэгсэл бүрт тахограф ашиглах заавар байршуулах.

## **ХОЁР. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД СУУРИЛУУЛСАН ТАХОГРАФТ ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ**

15. Бүртгэгдэж зөвшөөрөл авсан засвар үйлчилгээний газар дараах чиг үүрэгийг гүйцэтгэнэ:

15.1. тахографын бүрдэлийг тээврийн хэрэгсэлд суурилуулах, идэвхжүүлэх, ашиглалтад оруулах;

15.2. тахографт техникийн үйлчилгээ хийх;

15.3. тахографыг засварлах, “Тээврийн хэрэгсэлд суурилуулах тахограф болон картад тавигдах шаардлага”-д нийцэхгүй байгаа тахографт зохих өөрчлөлт оруулж нийцэлийг хангах, түүний дотор бүрдэл хэсэгийг солих, өөрчлөх, програм хангамжийг шинэчлэх (цаашид “тахографыг сайжруулах” гэх);

15.4. тахографыг солих;

15.5. тахографыг ашиглалтаас гаргах.

16. Тахографыг ашиглалтад оруулах ажиллагаанд дараах зүйлс хамаарна:

16.1. тахограф үйлдвэрлэгчийн техникийн баримт бичиг, зааварын дагуу тахографыг идэвхжүүлэх;

16.2. үйлдвэрлэгчийн техникийн баримт бичиг, зааварын дагуу тахографыг тохируулах, үйл ажиллагааг шалгах, хэмжилтийн үнэн зөвийг шалгах;

16.3. тахографын тухай өгөгдөлийг АТҮТ-д илгээх.

17. Тахографт техникийн үйлчилгээ хийх хүрээнд дараах ажиллагааг гүйцэтгэнэ:

17.1. тахографын ажиллагаа зөв эсэх, хэмжилт үнэн зөв байгааг шалгах;

17.2. тахографыг дахин тохируулах.

18. Тахографын ажиллагаа зөв эсэх, хэмжилт үнэн зөв байгааг шалгах болон дахин тохируулахад дараах нөхцөлийг сахин мөрдөнө:

- 18.1. ачаа, зорчигч байхгүй тээврийн хэрэгсэл, жолооч өөрөө байх;
  - 18.2. дугуйн хийн даралт тээврийн хэрэгсэлийн ердийн ашиглалтын стандартын дагуу байх;
  - 18.3. дугуйн элэгдэл тухайн ангилал, төрөлийн тээврийн хэрэгсэлийн техникийн үзлэгийн шаардлагад нийцэж байх;
  - 18.4. тээврийн хэрэгсэл өөрийн хөдөлгүүрийн хүчээр шулуун замаар тахограф үйлдвэрлэгчийн техникийн баримт бичиг тодорхойлсон зайг туулах юмуу туршилтын төхөөрөмж дээр хөдөлгөөний дууриалгах.
19. Тахографыг тохируулахад дараах ажиллагааг гүйцэтгэнэ:
- 19.1. цагийн бүсийн дагуу цагийн үзүүлэлтийг тохируулах;
  - 19.2. тухайн тээврийн хэрэгсэлийн хурдны хязгаарлалтын утгыг тахографт оруулах;
  - 19.3. тахографын тогтмол утга (k), тээврийн хэрэгсэлийн үзүүлэлтийн коэффициент (w), дугуйны идэвхтэй тойрог (l)-ийн утга, адилтгалын (VIN) болон улсын (бүртгэлийн) дугаарын (VRN) өгөгдөлийг шинэчлэх юмуу баталгаажуулах.
20. Тахографын тохируулгыг гурван жилд нэг удаа, эсхүл дараах нөхцөл үүссэн үед гүйцэтгэнэ:
- 20.1. тээврийн хэрэгсэлийн зүтгэх голын аль нэг дугуйны идэвхтэй тойрог өөрчлөгдөх;
  - 20.2. тээврийн хэрэгсэлийн үзүүлэлтийн коэффициент өөрчлөгдөх;
  - 20.3. тахографыг засварлах юмуу тахографыг сайжруулах;
  - 20.4. тахографыг лац өөрчлөгдсөн, эвдэрсэн байх.
21. Тахографыг тохируулж дууссаны дараа зөвшөөрөлгүй нээх, задлах, эд ангийг солих оролдлогыг илрүүлэх, эрх олгогдоогүй этгээд хандахаас сэргийлэх зорилгоор лацдана. Лацыг хөдөлгөөн мэдрэгчийн залгасан, байршуулсан хэсэг, тахографын бүх залгуур, тахограф болон хөдөлгөөн мэдрэгчийн холболтуудын залгуур дээр тавина.
22. Тахографын засвар болон сайжруулалтыг үйлдвэрлэгчийн техникийн баримт бичиг (засварлах заавар, суурилуулах заавар г.м)-ийн дагуу гүйцэтгэнэ.
23. Тахографын засвар болон сайжруулалт гүйцэтгэсэний дараа энэ журмын 16-д заасан ажиллагааг гүйцэтгэнэ.
24. Эвдэрсэн, ашиглалтын хугацаа дуусантай холбоотойгоор тахографыг солих ажиллагааг үйлдвэрлэгчийн техникийн баримт бичиг (суурилуулах заавар г.м)-ийн дагуу гүйцэтгэнэ.

25. Тахографыг ашиглах, үйлчилгээ хийх, засварлах болон ашиглалтаас гаргах үед түүний санах ойд бичигдсэн, бүртгэгдсэн мэдээлэлийг хэрэглэгч заавал татаж авч зохих ёсоор хадгална.

26. Эвдэрсэн, ашиглалтын хугацаа дуусантай холбоотойгоор тахографыг ашиглалтаас гаргасны дараа дараах ажиллагааг гүйцэтгэнэ:

26.1. засвар үйлчилгээний газар тахографын өгөгдөлийг гадаад тээгчид татаж авч байгууллагад хүлээлгэн өгнө;

26.2. тахографыг ашиглалтаас гаргасан тухай мэдээлэлийг бүртгэлд оруулахын тулд АТҮТ-д илгээнэ.

## **ГУРАВ. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД СУУРИЛУУЛСАН ТАХОГРАФЫН АЖИЛЛАГААГ ХЯНАХ.**

27. Тээврийн хэрэгсэл жолоодож буй жолооч тогтоосон хөдөлмөр амралтын горимыг зөрчихөөс сэргийлэх зорилгоор тээврийн хэрэгсэлд суурилуулсан тахографын ажиллагааг засвар үйлчилгээний газар болон тээврийн байгууллага, өмчлөгч хэрэгжүүлнэ.

28. Хяналт тавих явцад дараах шаардлагыг сахин мөрдөж буйг шалгана:

28.1. тахограф суурилуулсан тээврийн хэрэгсэл нь зохих төрөл ангилалд хамаарч буй эсэх;

28.2. тээврийн хэрэгсэлд суурилуулсан тахограф монгол улсад зөвшөөрөгдсөн загвар мөн, зохих бүртгэлд орсон гэдэгийг баталсан баримт бичигтэй эсэх;

28.3. тээврийн хэрэгсэлд суурилуулсан тахографыг зохих журамын дагуу идэвхжүүлсэн эсэх;

28.4. тахограф зөв ажиллаж байгаа, блоклогдоогүй, өөрчлөлт оруулаагүй;

28.5. тахографын бүртгэж буй мэдээлэл блоклогдоогүй, өөрчлөгдөөгүй;

28.6. тахограф дээр үйлдвэрийн баталгаа, өмнөх шалгалтын баталгаа наагдсан, өмнө шалгасан хүний гарын үсэг, тамгатай тэмдэглэгээг паспортод оруулсан эсэх.

29. Тахографын ажиллагааг хянах шалгалтын хуваарийг тээврийн байгууллага, өмчлөгч тогтоох бөгөөд шалгалтын хоорондын зай нэг жилээс хэтрэхгүй байна.

30. Хяналтын шалгалт дууссаны дараа засвар үйлчилгээний байгууллагын удирдах ажилтан тахографын паспортод шалгалтын явцад илэрсэн зүйл, нийцэл хангасан байдалын талаар тэмдэглэгээ хийж, огноо тавьж гарын үсэг зурж тамга дарна. Тахограф дээр хяналтын шалгалт хийгдсэн огноо бүхий тамгатай баталгаа наана.

31. Тээврийн хэрэгсэлийг ажилд оруулсаны дараа жолооч тахографын ажиллагааг

ашиглалтын зааварын дагуу хянана.

32. Хяналтын шалгалт хийх үед дараах ажиллагааг гүйцэтгэнэ:

32.1. тахографын бүрдэл хэсэгүүдийг харж шалгах, түүнийг суурилуулсан, холбосон байдалыг үйлдвэрлэгчийн шаардлагын дагуу шалгах;

32.2. тахографын баримт бичиг паспорт болон хэвлэсэн өгөгдөлүүдийг шалгах;

32.3. тахограф болон жолоочийн картаас өгөгдөлийг хэвлэж шалгах;

32.4. тахограф болон картаас өгөгдөл татаж шалгах;

32.5. хэвлэсэн өгөгдөлүүдийг тахограф болон картад хадгалагдаж (бүртгэгдсэн) буй өгөгдөлтэй харьцуулах;

32.6. дэлгэц дээр мэдээлэл харуулж буй байдалыг шалгах;

32.7. өдөр тутамын ажил юмуу ээлж эхлэх, дуусах үед тээврийн хэрэгсэлийн байршилын мэдээлэлийг гараар оруулах функцийг шалгах;

32.8. тээврийн хэрэгсэлийн байршилыг автоматаар тодорхойлох функцийг шалгах;

32.9. тээврийн хэрэгсэлийн бодит байршилыг тахографын санах ойд автоматаар бүртгэгдсэн байршилын мэдээлэлтэй харьцуулан шалгах.

32.10. тахограф дээрх лац, хяналтын шалгалт хийсэн баталгаа, паспорт дээрх хяналтын шалгалтын тэмдэглэгээ, тамга, гарын үсгийг шалгах.

---oOo---